

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


## ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдааны 46 дугаар тэмдэглэлд:

“III.ХЭЛЭЛЦСЭН нь: Өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх зорилгоор улсын нөөцөд өвс, тэжээл нэмж бүрдүүлэх, улсын нөөцийн түр цэг байгуулах тухай асуудлыг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдийн гаргасан саналын дагуу хойшлуулав.

Үүнтэй холбогдуулан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохих тооцоо, судалгаанд тулгуурлан үндэслэл сайтай боловсруулан Засгийн газрын 2009 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын хуралдааны журам”-ыг баримталж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хянуулсны үндсэн дээр хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулан хэлэлцүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР